


## “ ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 04 сарын 15

Сайнцагаан сум

Дундговь аймгийн ЗДТГ-ын хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулж байгаа “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аяны хүрээнд Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэг нь 2023 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд нэгдэж байгууллагын албан хаагчдад авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг таниулах, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

➤ Албан хаагчид болон эцэг эх, асран хамгаалагчдадаа соён гэгээрүүлэх зорилгоор олон талт арга хэмээнүүдийг үе шаттай зохион байгуулж, байгууллагын болон бүлгүүдийн самбар, цахим хуудас, фэйсбүүк хуудсанд мэдээллийг байршуулж олон нийтэд сурталчилан ажилласан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн богино хэмжээний видео, шторкыг байгууллагын “Дундговь 2-р цэцэрлэг” фэйсбүүк хуудас, анги бүлгүүдийн групп чатад байршуулан гарын авлага, шторкыг эцэг эх асран хамгаалагчдадаа түгээн дэлгэрүүлсэн.



➤ Сайнцагаан сумын төсөвт байгууллагын удирдлагуудын дунд зохион байгуулсан танин мэдэхүйн хөгжөөнт “ЦЕНТАВР” тэмцээнд эрхлэгч М.Туул амжилттай орлцсон.





танин  
хөгжөөнт  
тэмцээнд  
амжилттай


- Авлигын эсрэг хууль болон авлигатай тэмцэх газрын нээлттэй утас 110 дугаарыг сурталчилан таниулах үйл ажиллагааг зохион байгууллаа.



- Авлигатай тэмцэх газраас 2022 оны 11 дүгээр сарын 02- ны өдөр зохион байгуулсан “Авлигаас ангид боловсрол: Ёс зүй ба шударга байдал хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг багш, ажилчиддаа таниуулан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болголоо.



- “Багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм” сургалтыг Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч С.Алимаа нь багш, албан хаагчидад зохион байгуулсан.



Тайлантай танилцсан:  
 САЙНЦАГААН СУМЫН  
 2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ ( М.ТУУЛ)  
 Тайлан гаргасан:  
 2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН АРГА ЗҮЙЧ (М.УРТНАСАН )